



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар

8/42

Ховд


Албан үүргийг түр орлон
гүйцэтгүүлэх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.8, 43 дугаар зүйлийн 43.3.3, 43.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны (Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулах олгох журам) 9 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын зайлшгүй шаардлагаар Төрийн албаны тухай хуулийн дагуу сул орон тоог сонгон шалгаруулалтаар нөхөх хүртэлх хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Дүгэржавын Эрдэнэбатыг 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Д.Эрдэнэбатад Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан тушаалын сарын үндсэн цалингийн зөрүүг тооцон бодож, сар бүр олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн нягтлан бодогч (Б.Энхмандал)-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрд тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг Д.Эрдэнэбатад даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.ГАНБОЛД



8400003 0258
Tush B/42 Ba